

Газар хөдлөлт, гал түймэр, гамшигийн үед

Дүрвэх үед болон, газны үнэр гарах үед газ ашиглахаа зогсоож, төхөөрөмж, газны гол хаалт, тоолуурын газны хаалт болон баллоны хаалт бүгдийг хаана уу.



LP газны аюулгүй ажиллагааны тухай

LP газны аюулгүй ажиллагааг хангахын тулд хуульд заасны дагуу тогтмол мэдээллээр хангаж, үйлчлүүлэгчийн гэр болон ажлын байранд очиж аюулгүй байдлыг шалгадаг бөгөөд, зарим газны компани энэ ажлыг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаар гүйцэтгүүлдэг. Аюулгүйн ажиллагаа хариуцсан байгууллага танайд үзлэгээр очвол хамтран ажиллахыг хүсье.

Мэдээллээр хангах

Ажлын зориулалттай гал тогоог ашиглах үеийн анхаарах зүйлс, аюулгүй ажиллагааны мэдээлэл зэргийг бичгээр тогтмол мэдээлдэг.

**Жилд 1 удаа
(эсвэл 2 жилд 1 удаа)
хэрэгжүүлдэг**

◎ “Аюулгүй ажиллагааны үзлэг”-ийг үнэ төлбөргүй гүйцэтгэнэ. Харин “элэгддэг тоног төхөөрөмж”-ийг засах, шинэчлэх шаардлагатай үед төлбөр гарна.

СО, газ алдалтаас үүдэх ослыос урьдчилан сэргийлэх аюулгүйн төхөөрөмж сууринуулахыг зөвлөж байна.

✓ Ажлын зориулалттай агааржуулалтын мэдрэгч

Агаарын солилцоо хийх шаардлагатай, мөн СО ялгарсан үед шууд мэдрэч, аюул нүүрлэхийн өмнө мэдэгдэнэ. Цахилгаанд залгах шаардлагагүй, зайгаар ажилладаг мэдрэгч ч байдаг.



Ажлын зориулалттай агааржуулалтын мэдрэгчийн жишээ

✓ Газ мэдрэгч

Газ алдах осол нь ихэвчлэн “ассан гэж бодсон” анзарагагүй гэх алдаа болон шингэн гадагш хальснаас үүддэг. Энэ төрлийн ослыос урьдчилан сэргийлэхийн тулд мэдрэгч сууринуулахыг зөвлөж байна.

**Мэдрэгчийг 5 ЖИЛД НЭГ УДАА СОЛИХ шаардлагатай.
Хугацаа дууссан төхөөрөмж буруу ажиллах эрсдэлтэй.**

LP газны ослын дуудлагын утас

Холбоо барих хаяг:

Утас:

Ослын дуудлагын утас 24 цагаар ажилладаг.

LP газны компанийн нэр

Ажлын зориулалттай LP газны аюулгүйн зааварчилгаа

Аюулгүй, найдвартай ашиглахын тулд

Гал тогоонд ажиллах хүмүүсийн нүдэнд тусах газар тавина уу.



**Газ үнэртэж байгааг мэдрэвэл,
Тийм үед авах арга хэмжээ нь!**


✓ Гал ашиглаж огт болохгүй.

- Гал авалцах шалгаан болох учир гал гаргахгүй, мөн агааржуулалтын сэнс болон гэрлийн унтраалгад ч огт хүрч болохгүй.



Гал гаргахыг хатуу хориглоно

✓ Хаалга, цонхoo том онгойлгож, газыг гадагшлуулаарай.



- LP газ нь агаараас хүнд учир нам доор газарт хуримтлагдаж үлддэгийг анхаарна уу.

- Тоолуурын газны хаалтын байрлалыг мэдэхгүй бол LP газны компаниас урьдчилан лавлана уу.



- Тоолуурын газны хаалт эсвэл баллоны хаалтыг заавал хаана уу.

✓ Газ алдагдаж буй нөхцөл байдлыг шууд мэдээлнэ үү.



- Аюулгүй газарт зугатах тухай заавар ирсэн тохиолдолд үйлчлүүлэгчийг зугатахад нь тусална уу.

- Ослын дуудлагын утсыг LP газны компаниас урьдчилан лавлана уу.
- Ослын дуудлагын утас 24 цагаар ажилладаг.

Газны төхөөрөмж ашиглах үед агаарын солилцоог заавал хийнэ үү!

Газны төхөөрөмж ашиглах үед агаарын солилцоо болон агааржуулалтын хоолойн амсрыг заавал шалгана уу.



Газ алдагдахаас сэргийлэхийн тулд!

✓ Гал ноцсон эсэхийг шалгах

✓ Төхөөрөмжийн хаалтыг хаахаа мартаагүй эсэх

- Заавал нүдэрээр шалгах!
- Ашиглах дуусаад төхөөрөмжийн хаалт бүрэн хаагдсан эсэхийг шалгах!

Аюулгүйн төхөөрөмжгүй тоног төхөөрөмжийг ашиглахдаа онцгойлон анхаарна уу.




✓ Дахиж даран, галыг ахин ноцоох

✓ Дутуу ноцож унтрах

- Дахин ноцоох үед онцгойлон анхаарна уу.
- Тухайн газрыг орхилгүй өөрийн нүдэр шалгана уу.
- Шатаах төхөөрөмж хуучирч муудаагүй, эвдрээгүй эсэхийг анхаарна уу.

✓ Резин хоолой (резин гуурс) нь

- Шатсан, цуурал үүсээгүй эсэх!
- Газны гол хаалт дахь улаан зураас хүртэл угласан байгаа эсэх!
- Даравчаар найдвартай тогтоосон эсэх




✓ Ашиглахгүй газны гол хаалт нь

- Хаалтын чих “хаах” дээр байгаа эсэх!
- Газны гол хаалтын резин таг таглаатай байгаа эсэх!

СО хордлогод орох ослоос сэргийлэхийн тулд!

✓ Агааржуулалтыг шалгах

- Хоолны бэлтгэл ажлын үеэр болон ажлын цаг эхлэх үед агааржуулалтын сэнс ажиллаж буй эсэхийг заавал шалгах!




✓ Дакт зэрэг агааржуулалтын төхөөрөмжийн цэвэрлэгээ

- Агааржуулалтын сэнс, хиншүү сорогч, дакт зэргийн дотор талыг тогтмол цэвэрлэнэ уу.
- Агааржуулалтын хоолой (яндан) цоорсон, мултарсан, зэвэрсэн эсэхийг анхаарна уу. Угаарын хий гал тогоо руу урсаж ордог.



✓ Агааржуулагчийн амсрыг шалгах

- Агааржуулагчийн амсрыг юмаар хаагаагүй эсэхийг шалгах!



Аюулгүй байдлыг шалгах!

СО (нүүрс төрөгчийн дутуу исэл)-ийн хордлогын тухай!

Галын төхөөрөмжийг агаар (хүчилтөрөгч)-ын дутмаг байдалд ашигласнаар дутуу шаталт үүсэж, СО (нүүрс төрөгчийн дутуу исэл) ялгардаг. СО нь маш хортой бодис бөгөөд бага хэмжээгээр амьсгалах төдийд л толгой өвдөн дотор муухайрч, нэг мэдэхэд хөдөлж чадахгүй болж үхэлд хүргэх аюултай. СО мэдрэгч тавихыг зөвлөж байна.



Болзошгүй ...-ын тулд!

✓ Ажлын байрны агааржуулалт мэдрэгч (СО мэдрэгч)

✓ Газ мэдрэгч


- Цэвэрлэгээ хийх зэрээр түр салгах тохиолдолд заавал буцааж залгана уу.

✓ Газ ашиглаж байгаад хоорондоо хүлээлцэх үед

- Газ ашиглаж байгаад хоорондоо ээлж солигдох үед дараагийн хүндээ нөхцөл байдлыг тайлбарлаж, хүлээлцэнэ уу.

✓ Ажил дуусах үед

- Газны гол хаалтыг хаасан эсэхийг нэг бүрчлэн хуруугаар зааж шалгана уу.



Ийм үед шууд холбогдоорой!

Дөл

Дөл тогтвортгуй

Дөл шар өнгөтэй

Дөлгүй хэсэг байх

Ажиллагаа

Ашиглаж байхад унтрах

Хүчтэй авалцаж асах

Гал жигд тархан асахгүй байх

Асахдаа муу байх

Асахгүй байх

Тоног төхөөрөмж

Хачин дуу гарч шатах

Газны үнэр үнэртэх

Ажиллаж байх үед угаарын хийн үнэр үнэртэх

Төхөөрөмж үйлдвэрлэгч эсвэл LP газны компанид шууд шалгуулах хүсэлт өгнө уу.